



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 1/106

Амардалай

Нутгийн монгол үүлдрийн бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэгжүүлж, бүртгэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.3 заалт, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 09 дугаар сарын А/473 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 09 дугаар сарын А/531 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын хээлтүүлэгчийг технологийн хугацаанд нь үзлэг, ангилалт хийж баталгаажуулж, ялган тэмдэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баттогтох (ХААТ-ийн мэргэжилтэн)

Гишүүд: Д.Ариунгэрэл (Адаацаг ажнай ХХК-ны дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

2. Тухай ажлыг мэргэжлийн мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, малын бүртгэл мэдээллийн санд хамруулахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлт хийх ажлын явцад хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, тайлан мэдээг нэгтгэж 2023 оны 10 дугаар сарын 05-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Баттогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ